**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/74/НА-СТА-ТШЗ

| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn | 2024 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл ......................................................................................................................

4.2 Материаллаг байдал ........................................................................................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..............................................................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...............................................................................

5. Аудитын илрүүлэлт ..............................................................................................................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Аудитын код: БНА-2024/74/НА-СТА-ТШЗ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/72

танай___________-ны № _____________ -т

БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЭРДЭМ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.ЗАГДСҮМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэм Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрдэм ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Чиглэл батлах тухай” 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр 38,186.5 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мөн 113,274.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,674.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө 6,134.9 мянган төгрөгөөр нэмэгджээ.

5020275

**Аудитын гол асуудал**

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 234,050.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 800,061,694.00 | 2,683,841,893.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,089,100.00 | 37,276,493.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,089,100.00 | 37,276,493.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 25,220,550.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,385,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 13,800,350.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/ | - | 4,035,100.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/ | 3,605,800.00 | 8,305,943.00 |
| 120009 | Бусад орлого | 483,300.00 | 3,750,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 795,972,594.00 | 2,646,565,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,230,400.00 | 2,377,872,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,230,400.00 | 2,377,872,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 82,368,794.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 82,368,794.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104,373,400.00 | 268,692,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуллага/ | 104,373,400.00 | 268,692,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 798,866,815.00 | 2,730,433,137.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 798,866,815.00 | 2,730,433,137.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 674,746,483.00 | 2,573,228,548.56 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 467,851,408.72 | 1,814,214,107.28 |
| 210101 | Цалин | 287,734,198.98 | 1,271,424,941.23 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 148,541,667.74 | 458,674,153.98 |
| 210104 | Урамшуулал | - | 84,115,012.07 |
| 210105 | Гэрээтийн цалин | 31,575,542.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 58,284,100.02 | 227,225,319.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 42,738,686.02 | 155,801,511.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,808,663.00 | 18,023,041.92 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,826,000.00 | 14,530,369.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 249,048.00 | 3,533,668.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 8,661,703.00 | 35,336,727.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 106,048,914.00 | 261,559,077.50 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,249,546.00 | 12,368,515.50 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 92,120,736.00 | 221,089,630.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 9,678,632.00 | 28,100,932.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,899,226.00 | 32,516,941.81 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 1,500,600.00 | 22,390,470.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 530,000.00 | - |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 117,926.00 | 1,027,521.81 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | - | 1,827,100.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 200,000.00 | 550,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,494,900.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 6,721,850.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | 3,055,800.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 1,741,300.00 | 1,065,310.00 |
| 210501 | Эм | 1,741,300.00 | 1,065,310.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 8,674,450.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 8,674,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,080,000.00 | 720,400.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 1,080,000.00 | 720,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 312,400.00 | 19,497,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,385,100.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 312,400.00 | 12,111,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,529,134.26 | 207,755,942.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,000.00 | 46,888,250.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 7,652,900.00 | 4,157,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,809,234.26 | 156,710,692.48 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,120,332.00 | 157,204,588.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 124,120,332.00 | 157,070,516.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 45,733,500.00 | 118,884,000.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,386,832.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 38,186,516.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 134,072.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 134,072.50 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 1,194,879.00 | (46,591,244.06) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 20,000.15 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 20,000.15 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | - | (20,000.15) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 1,194,879.00 | (46,611,244.21) |

### 2.3 Аудит хийсэн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 796,455,894.00 | 2,671,500,850.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 483,300.00 | 24,935,450.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 483,300.00 | 24,935,450.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 21,185,450.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,385,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 13,800,350.00 |
| 120009 | Бусад орлого | 483,300.00 | 3,750,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 795,972,594.00 | 2,646,565,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,230,400.00 | 2,377,872,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,230,400.00 | 2,377,872,800.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 82,368,794.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 82,368,794.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104,373,400.00 | 268,692,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104,373,400.00 | 268,692,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 731,576,036.00 | 2,579,625,744.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 731,576,036.00 | 2,579,625,744.58 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 607,455,704.00 | 2,422,421,156.08 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 466,604,602.00 | 1,814,214,107.28 |
| 210101 | Үндсэн цалин | 286,254,005.00 | 1,271,424,941.23 |
| 210102 | Нэмэгдэл | 149,071,550.00 | 458,674,153.98 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | - | 84,115,012.07 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31,279,047.00 | - |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 58,489,714.00 | 227,225,319.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 42,971,300.00 | 155,801,511.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,808,663.00 | 18,023,041.92 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,826,000.00 | 14,530,369.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 249,048.00 | 3,533,668.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 8,634,703.00 | 35,336,727.52 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 68,928,362.00 | 261,559,077.50 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,249,546.00 | 12,368,515.50 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 55,000,184.00 | 221,089,630.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 9,678,632.00 | 28,100,932.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 7,182,450.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 7,182,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 720,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 720,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 430,326.00 | 22,072,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,385,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 430,326.00 | 14,686,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,002,700.00 | 89,447,801.81 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,613,200.00 | 67,705,831.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 10,389,500.00 | 21,741,970.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,120,332.00 | 157,204,588.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 124,120,332.00 | 157,070,516.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 45,733,500.00 | 118,884,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,386,832.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 38,186,516.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 134,072.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 134,072.50 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 64,879,858.00 | 91,875,105.42 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | - | 73,407,800.00 |

Аудитын код: БНА-2024/74/НА-СТА-ТШЗ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 73,407,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 73,407,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 73,407,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (73,407,800.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 64,879,858.00 | 18,467,305.42 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 217,359,952.21 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 217,359,952.21 | 235,701,857.63 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | -12,164,068.60 | 2,514,884,736.24 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | -12,164,068.60 | 2,514,884,736.24 |
| 3 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 1,194,879.00 | 1,194,879.00 |
| 4 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | 465,757,051.26 | 2,992,805,856.10 |
| 5 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | 465,757,051.26 | 2,992,805,856.10 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | 465,757,051.26 | 2,992,805,856.10 |
| 7 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | -46,611,244.21 | -46,611,244.21 |
| 8 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,627,034,865.06 | 900,013,939.78 | 419,145,807.05 | 2,946,194,611.89 |

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,891,074,300.00** | **2,643,399,472.10** | **247,674,827.90** | **91.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **2,891,074,300.00** | **2,643,399,472.10** | **247,674,827.90** | **91.4** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **2,711,390,600.00** | **2,486,328,956.10** | **225,061,643.90** | **91.7** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,002,433,800.00 | 1,804,714,107.30 | 197,719,692.70 | 90.1 |
| 210101 | Үндсэн цалин | 1,385,330,000.00 | 1,261,924,941.20 | 123,405,058.80 | 91.1 |
| 210102 | Нэмэгдэл | 521,576,400.00 | 458,674,154.00 | 62,902,246.00 | 87.9 |
| 210104 | Урамшуулал | 95,527,400.00 | 84,115,012.10 | 11,412,387.90 | 88.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **250,285,600.00** | **227,225,319.50** | **23,060,280.50** | **90.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 170,188,200.00 | 155,801,511.40 | 14,386,688.60 | 91.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,024,400.00 | 18,023,041.90 | 2,001,358.10 | 90.0 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 16,019,500.00 | 14,530,369.70 | 1,489,130.30 | 90.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,004,800.00 | 3,533,668.90 | 471,131.10 | 88.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,048,700.00 | 35,336,727.50 | 4,711,972.50 | 88.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **264,692,600.00** | **261,559,077.50** | **3,133,522.50** | **98.8** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 11,431,500.00 | 12,368,515.50 | -937,015.50 | 108.2 |
| 210302 | Түлш, халаалт | 221,090,100.00 | 221,089,630.00 | 470 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,171,000.00 | 28,100,932.00 | 4,070,068.00 | 87.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,000,000.00** | **7,182,450.00** | **-3,182,450.00** | **179.6** |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 7,182,450.00 | -3,182,450.00 | 179.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **720,400.00** | **-720,400.00** | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 720,400.00 | -720,400.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **22,131,900.00** | **22,072,000.00** | **59,900.00** | **99.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,444,600.00 | 7,385,100.00 | 59,500.00 | 99.2 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 14,687,300.00 | 14,686,900.00 | 400 | 100.0 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **167,846,700.00** | **162,855,601.80** | **4,991,098.20** | **97.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,815,800.00 | 140,833,631.80 | 4,982,168.20 | 96.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,030,900.00 | 22,021,970.00 | 8,930.00 | 99.9 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **179,683,700.00** | **157,070,516.00** | **22,613,184.00** | **87.4** |
| **ху** | **Бусад урсгал шилжүүлэг** | **179,683,700.00** | **157,070,516.00** | **22,613,184.00** | **87.4** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 141,496,700.00 | 118,884,000.00 | 22,612,700.00 | 84 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 38,187,000.00 | 38,186,516.00 | 484 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,891,074,300.00** | **2,667,616,777.50** | **223,457,522.50** | **92.3** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,377,872,800.00** | **2,377,872,800.00** | **-** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,377,872,800.00 | 2,377,872,800.00 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **268,692,600.00** | **268,558,527.50** | **134,072.50** | **100.0** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 268,692,600.00 | 268,558,527.50 | 134,072.50 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **244,508,900.00** | **21,185,450.00** | **223,323,450.00** | **8.6** |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,407,000.00 | 10,869,100.00 | -3,462,100.00 | 147 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,742,000.00 | 10,316,350.00 | 9,425,650.00 | 52.3 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 217,359,900.00 | - | 217,359,900.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 217,359,952.20 | -217,359,952.20 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 235,701,857.60 | -235,701,857.60 | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **102** | **98** | **4** | **96.1** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 85 | 84 | 1 | 98.8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 13 | 3 | 81.3 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь даараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**3.2** Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,611.2 мянган төгрөгөөр буюу 3.2 дахин өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 217,359.9 | 235,701.9 | 18,342.0 |
| Авлага | 45,640.0 | | -45,640.0 |
| Бараа материал | 135,986.1 | 150,320.8 | 14,334.7 |
| Үндсэн хөрөнгө | 2,593,819.7 | 2,560,171.9 | -33,647.8 |
| **Нийт хөрөнгө** | **2,992,805.8** | **2,946,194.6** | -46,611.2 |
| Засгийн газрын хувь оролцоо | **2,992,805.8** | **2,946,194.6** | -46,611.2 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,992,805.8** | **2,946,194.6** | -46,611.2 |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 235,701.8 мянган төгрөг болж 18,342.0 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.
- Авлагын дансны оны эхний үлдэгдлийг барагдуулсантай холбоотой авлагын үлдэгдэлгүй байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 150,320.8 мянган төгрөг болж, 14,334.7 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтай материал 6,140.5 мянган төгрөг, аж ахуйн материал 20.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 8,174.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,560,171.9 мянган төгрөг болж, 33,647.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 119,047.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө 4,035.1 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ИргэдийнТөлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 12-ний 14/28 тоот тогтоолоор актласан үндсэн хөрөнгө 279,162.4 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэлын зардал 156,710.7 мянган төгрөг актласан хөрөнгийн элэгдэл 279,142.4 мянган төгрөг гарсантай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,946,194.6 мянган төгрөг болж 46,611.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,883,780.2 мянган төгрөгөөр, нийт зардал өмнөх оноос 1,931,566.3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,388,330.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 258,990.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 2,622,381.7 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 268,692.6 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 234,050.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 9,702,1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 21 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс төсвөөс 2,377,872.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 10,869.1 мянган төгрөг,туслах үйл ажиллагааны орлогоос 10,316.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 268,692.6 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,377,872.8 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоос 21,185.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 2,031,939.4 мянган төгрөг, нормативт зардалд 22,975.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 157,070.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 162,855.6 мянган төгрөг, нийт 2,374,840.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 268,692.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж байр ашиглалтын зардалд 261,559.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 6,999.5 мянган төгрөг, нийт 268,558.5 мянган төгрөгийг зарцуулж 134,072.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,374,840.9 мянган төгрөг буюу 90.1 хувь, орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 268,558.5 мянган төгрөг буюу 99.9 хувь байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* *[мянган төгрөг]*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 71601 | Ерөнхий боловсролын сургалт | 2,622,381.7 | 2,374,840.9 | 247,540.8 | 90.1 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,420,566.1 | 2,195,698.4 | 224,867.7 | 91.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 179,683.7 | 157,070.5 | 22,613.2 | 87.4 |
| 83112 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 22,131.9 | 22,072.0 | 59.9 | 99.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, худалдан авах 203,496.7 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 180,884.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөр хүнсний материал нээлттэй тендер шалгаруулах журмаар 118,884.0 мянган төгрөг, Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 62,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар цахим дэлгүүрээс , тоног төхөөрөмж 57,047.8 мянган төгрөг, хангамж бичиг хэргийн материал 56,160.9 мянган төгрөг нийт 113,208.7 мянган төгрөгийн бараа материал, тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар худалдаж авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,645,565.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 26,465.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материалаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 18,526.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 220,779.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 22,613.2 мянган төгрөгийн зардлуудыг хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,593,631.0 мянган төгрөгийн 53 мэдээлэл мэдээлэхээс 2,465,003.0 мянган төгрөгийн 48 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 128,628.0 мянган төгрөгийн 5 мэдээлэл мэдээллэгүй, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн 99 мэдээлэл мэдээлэхээс 96 мэдээлэлийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн, ил тод байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

**4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй, худалдан авах ажиллагаа, байгууллагын орон тоо, архивын бүрдэл, хадгалалт хамгаалалт, эд хөрөнгийн эзэмшил, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсарын аудитын талаар**

Завсарын аудит хийгээгүй

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,889.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 5,889.0 | 1 | 5,889.0 | 100.0 |
| **Нийт дүн** | 1 | 5,889.0 | 1 | 5,889.0 | 100.0 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 131,650.8 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 3,022.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 128,628.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 3,022.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 26,465.7 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Санхүүгийн жилд 1 ажилтанд олгох улирлын үр дүнгийн урамшууллыг 240 хувиас хэтрүүлэхгүйгээр олгох журмыг зөрчиж нэр бүхий удирдах ажилтнуудад үр дүнгийн урамшууллыг илүү олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4."улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох"., Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 252 тогтоол Журам батлах тухай 4.4".Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгоход энэ журмын 4.4.1, 4.4.2-т заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, уг урамшуулалд зориулан батлагдсан тухайн жилийн төсөвт багтаан олгоно, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 3,022.8 мянган төгрөгийг захирал Ц.Загдсүмээр төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 03 дүгээр сарын 23-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Удирдах 5 ажилтанд олгох мөнгөн урамшуулал 3,022.8 мянган төгрөгийг давхардуулж олгосон байна. | 1 | 3,022.8 | 1 | 3.022.8 | | | | |

Аудитын код: БНА-2024/74/НА-СТА-ТШ3

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **1** | **3,022.8** | **1** | **3.022.8** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил*** | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт цалингийн зардлаас бусад орлогын 128,628.0 мянган төгрөгийн 5 мэдээлэл мэдээллээгүй, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн 99 мэдээлэл мэдээлэхээс 96 мэдээлэлийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна. | 1 | 128,628.0 | | | 1 | 128,628.0 |
| **Дүн** | **1** | **128,628.0** | | | **1** | **128,628.0** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ